



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/452

Улаанбаатар хот

"Улаанбаатар-2018" олон улсын аялал  
жуулчлалын үзэсгэлэн зохион  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "а", 29.2, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 3/08 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 1.4.6, 1.4.7, 2017 оны 01/19 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийн 1.4.5, 2017 оны 02/22 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын салбарт бараа бүтээгдэхүүн нийлүүлж, үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудыг нэг цэгээс хэрэглэгчидтэй уулзуулж, аялагч, амрагчдыг аяллын талаарх мэдээ, мэдээлэл авах боломжийг бүрдүүлэх зорилгоор "Улаанбаатар-2018" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнг 2018 оны 06 дугаар сарын 02-03-ны өдрүүдэд Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд зохион байгуулсугай.

2."Улаанбаатар-2018" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралт ёсоор баталсугай.

3."Улаанбаатар-2018" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн зохион байгуулахад шаардагдах, энэ захирамжийн 2 дугаар хавсралтаар баталсан 16,973,700 /арван зургаан сая есөн зуун далан гурван мянга долоон зуун/ төгрөгийг нийслэлийн 2018 оны төсөвт тусгасан "Зүүн хойд Азийн бизнес, аялал жуулчлал, соёл, санхүүгийн төв болох арга хэмжээний зардал"-аас гаргахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Э.Ганхүү/-т зөвшөөрсүгэй.

4."Улаанбаатар-2018" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнг зохион байгуулах арга хэмжээний удирдамжийг батлан, өндөр хэмжээнд зохион байгуулж, дүнг 2018 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор танилцуулахыг Нийслэлийн Засаг даргын ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогч Ж.Батбаясгаланд, уг арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд сурталчлахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс /Э.Дагиймаа/-т тус тус даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ

  
С.БАТБОЛД

Нийслэлийн Засаг даргын 2018 о  
05 дугаар сарын 17-ны өд  
А/152-р захирамжийн 1 дү  
хавс

#### АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга

-Нийслэлийн Засаг даргын Ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогч

Гишүүд

-Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Аялал жуулчлалын Бодлого зохицуулалтын газрын дарга /зөвшилцсөнөөр/;

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцааны хэлтсийн дарга;

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга;

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга;

-Нийслэлийн Цагдаагийн газрын дарга;

-Нийслэлийн Соёл, урлагийн газрын дарга;

-Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газрын дарга;

-Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга;

-“Үндэсний цэцэрлэгт хүрээлэн” ОНӨТҮГ-ын дарга;

-“Улаанбаатар чуулга” ОНӨҮГ-ын дарга;

-“Улаанбаатар аялал жуулчлалын холбоо” ТББ /тохиролцсоноор/.

Нарийн бичгийн дарга

-Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга.